



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/536

Улаанбаатар хот

Дүрэм, жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллага дахь халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааны дүрэм”-ийг нэгдүгээр, “Тархвар/халдвар судлаачийн, халдвар, хяналтын эмч, сувилагчийн ажлын чиг үүрэг”-ийг хоёрдугаар, “Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад хийгдэх үйл ажиллагааны жагсаалт”-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмыг мөрдүүлж, удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулж, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

4. Энэ тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Тархвар/халдвар судлаачийн ажлын чиг үүрэг”-ийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн албан тушаалын тодорхойлолтын дагуу албажуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

5. Тушаал шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын “Дүрэм, журам батлах тухай” 2014 оны 186, “Халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоог бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2017 оны А/169 тоот тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

082059



Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29-ны  
өдрийн 4/33 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагууд энэхүү дүрмийг мөрдөж ажиллана.

1.2. Халдварын сэргийлэлт, хяналт (цаашид ХСХ гэх) нь эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад, үйлчлүүлэгч, тэдний гэр бүл болон бусад иргэд эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагааны хэм хэмжээ юм.

1.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар (цаашид ЭТҮХХ гэх) гэдэг нь эрүүл мэндийн байгууллагад хийгдсэн эмчилгээ, үйлчилгээний явцад үйлчлүүлэгч шинээр халдвар авч халдварын шинж тэмдэг нь эмнэлэгт хэвтсэнээс хойш 24 цаг ба түүнээс хойших хугацаанд, эмнэлгээс гарсны дараах 1 сар, эрхтэн шилжүүлэн суулгах, хиймэл эд эрхтэн суулгах ажилбарын дараах 1 жил хүртэл хугацаанд илэрсэн халдвар, эрүүл мэндийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх явцад халдварт өртөх тохиолдол юм.

1.4. ХСХ-ын тогтолцооны зорилго нь ЭТҮХХ-аас сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлж хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд оршино.

1.5. Халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоо нь дараахь бүтэц зохион байгуулалттай байна.

1.5.1. Үндэсний түвшинд Эрүүл мэндийн яамны дэргэд халдварын, сэргийлэлт хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайд батална.

1.5.2. Халдварын, сэргийлэлт хяналтын чиглэлээр гарсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйгээр хангах ЭТҮХХ-ыг тандан судлах, дүгнэлт гаргах үүргийг Халдварт өвчин судлалын үндэсний төв (цаашид ХӨСҮТ гэх) гүйцэтгэнэ. ХӨСҮТ нь ажлын албатай байх ба албаны дарга нь тус төвийн тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал байна. Ажлын албаны бүрэлдэхүүнийг ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын тушаалаар томилно.

1.5.3. Аймаг, Нийслэлд халдварын сэргийлэлт, хяналтыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий салбар зөвлөл ажиллана. Зөвлөл нь тухайн орон нутгийн засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн газар, мэргэжлийн хяналтын алба, төр, хувийн хэвшлийн эмнэлгийн төлөөллөөс бүрдэнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн газрын дарга санал болгон, Аймаг, Нийслэлийн Засаг даргаар баталгаажуулна.

1.5.4. Төрөлжсөн мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, төв эмнэлэг, БОЭТ, аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газруудад халдварын сэргийлэлт, хяналтын асуудлыг хариуцаж, хэрэгжилтийг хангуулах, дотоодын хяналт тавих үүрэг бүхий халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны болон орон тооны бус алба/баг ажиллана.

1.5.4.1. ХСХ-ын алба орон тооны албаны бүрэлдэхүүнд халдвар хяналтын асуудал хариуцсан эмнэлзүйч эмч (цаашид халдвар хяналтын эмч гэх), тархвар/халдвар судлаачид, халдвар хяналтын сувилагч ажиллана. Байгууллагын бүтэц үйл ажиллагааны стандартаас хамаарна.

1.5.4.2. Орон тооны бус ХСХ-ын алба/баг, гишүүдийг байгууллагын даргын шийдвэрээр томилж ажиллуулна. Үүнд тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдал, тархвар судлал, хүний нөөц, лаборатори, сувилахуй, эм зүй, бичил амь судлаач, санхүү, аж ахуй, эмчилгээний асуудал хариуцсан мэргэжилтнийг оролцуулсан байна.

1.5.5. Өрх, сумын эрүүл мэндийн төв, клиник болон бусад эрүүл мэндийн байгууллагад орон тооны бус ХСХ-ын багийг байгууллагын даргын шийдвэрээр томилж ажиллуулна. Бүрэлдэхүүнд эмнэлзүйч, сувилахуй, лаборатори, тархвар судлал, санхүү, аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтнийг оролцуулсан байна.

### **Хоёр. Эрүүл мэндийн яамны дэргэдэх халдварын сэргийлэлт, хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөлийн ажлын чиг үүрэг, эрх**

2.1. ХСХ-ын бодлого, стратегийг боловсруулж, мэргэжил аргагүйн удирдлагаар ханган ажиллана.

2.2. ХСХ-ын ажлын үр дүн, холбогдох хууль тогтоомж, тушаал заавар, хөтөлбөр стандарт зэрэг эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг хэлэлцэж, шийдвэр гаргана.

2.3. ХСХ-ын тулгамдсан асуудлыг тодорхойлон Эрүүл мэндийн яамны удирдлагын зөвлөлд тайлагнах, шаардлагатай асуудлаар санал оруулна.

2.4. ХСХ-ын асуудлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх багийг томилон ажиллуулж болно.

2.5. ЭТҮХХ-ын дэгдэлт гарч нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүссэн үед асуудлыг нэн даруй шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

2.6. ХСХ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, судалгаа, дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагаас тогтоосон хугацаанд гаргуулан авч нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлнэ.

2.7. Тайлан, мэдээнд дүгнэлт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгуулна.

2.8. Зөвлөлийн ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна. Зөвлөлийн хурлыг гишүүдийн 75 хувиас дээш ирцийг бүрдүүлсэн тохиолдолд хүчинтэйд тооцно. Шаардлагатай тохиолдолд ЭМЯ-ны дэргэдэх бусад холбогдох

мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөллийг оролцуулан хуралдааныг өргөтгөсөн хэлбэрээр хийж болно.

2.9. Зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн асуудлыг Эрүүл мэндийн сайдад танилцуулж шийдвэр гаргуулна. Тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, дэд дарга нар хянаж гарын үсэг зурж, баталгаажуулна.

2.10. Зөвлөл нь ажлын албатай байх ба ажлын албаны үүргийг Халдварт өвчин судлалын үндэсний төв гүйцэтгэнэ.

### **Гурав. Халдварын сэргийлэлт, хяналтын зөвлөлийн ажлын албаны үүрэг.**

3.1. Улсын хэмжээнд ХСХ-ын чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ.

3.2. ХСХ-ын үйл ажиллагааны ойрын болон хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулахад санал өгнө.

3.3. ЭТҮХХ-ын байдалд дүн шинжилгээ хийж, эрүүл мэндийн байгууллагыг улирал тутам эргэн мэдээллээр хангах, ЭМЯ-ны дэргэдэх ХСХ-ын зөвлөлд хагас, бүтэн жилээр тайлагнаж, удирдамж чиглэл авч ажиллана.

3.4. Эрүүл мэндийн байгууллагууд, түүний ХСХ-ын салбар зөвлөл, багуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэлт, дүгнэлт өгч авах арга хэмжээний зөвлөмж гаргаж, биелэлтийг хангуулна.

3.5. Тусламж, үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологийн халдварын эрсдлийг судалж, шинэ багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнийг хэрэглэх зөвшөөрөл олгоход санал, дүгнэлт гаргана.

3.6. ХСХ-ын сургалт, мэдээллээр хангах, эрүүл мэндийн мэргэжилтнийг сургах, мэргэжил дээшлүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.7. ХСХ-ын удирдамж, заавар, гарын авлагуудыг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх арга зүйгээр хангах, гадны улс орнуудын сайн туршлагыг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

3.8. ЭМБ-ын ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэх саналыг ЭМЯ болон ХСХ-ын зөвлөлд танилцуулна.

3.9. ЭТҮХХ-ын чиглэлээр тандалт, судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран хийж үр дүнг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.10. Эрүүл мэндийн байгууллагаас ажлын мэдээ тайлан судалгаа дүгнэлт гаргуулж, үнэлэлт дүгнэлт өгнө.

3.11. ХСХ-ын чиглэлээр олон улсын туршлага судлах, зөвлөх үйлчилгээг авч ажиллана.

3.12. Улс, хувийн хэвшлийн бүх шатны ЭМБ-аас шаардлагатай баримт бичиг, үйл ажиллагаатай танилцах, ажлын чиглэл, зөвлөмж өгнө.

## **Дөрөв. Аймаг, нийслэлийн халдварын сэргийлэлт, хяналтын салбар, зөвлөлийн чиг үүрэг**

4.1. ХСХ-ын чиглэлээр гарсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллана.

4.2. Орон нутгийн онцлогт тохирсон ХСХ-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллана.

4.3. Харьяалах нутаг дэвсгэр дэх төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ХСХ-ын холбоотой асуудлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

4.4. Харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагын хяналт үнэлгээгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар үүрэг, даалгавар өгч хариуцлага тооцно.

4.5. Аймаг, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн ЭТҮХХ-ын байдалд дүн шинжилгээ хийж, улирал тутам хэлэлцэн, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэнэ.

4.6. Тайлан, мэдээнд дүгнэлт гаргаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохицуулах, албан даалгавар гаргана.

4.7. Холбогдох мэдээ, мэдээлэл, судалгаа, дүгнэлтийг ЭМБ-аас тогтоосон хугацаанд гаргуулан авна.

4.8. Салбар зөвлөл нь ХСХ-ийн холбоотой асуудлаар мэргэжлийн байгууллагаас мэргэжил арга зүйн дэмжлэг авна.

4.9. ЭТҮХХ-аас сэргийлэх ажилд амжилт гаргасан, дэмжлэг үзүүлсэн байгууллага, хамт олон, эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагаа, туршлагыг сурталчлах, урамшуулах ажлыг зохион байгуулна.

4.10. Салбар зөвлөл нь улирал тутам хуралдана. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлыг Зөвлөлийн дарга, түүний эзгүйд дэд дарга удирдана.

4.11. Салбар зөвлөл нь хуралдааны талаар хурлын тэмдэглэл хөтөлж, олонхийн саналаар шийдвэрлэсэн асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэр гаргуулна. Тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, дэд дарга нар хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.

4.12. Салбар зөвлөл нь хийсэн ажлаа хагас жил тутамд Эрүүл мэндийн сайдын дэргэдэх ХСХ-ыг зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, аймаг, нийслэлийн засаг даргад ажлаа тайлагнана.

4.13. ХСХ-ын үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн болон мэргэжлийн асуудлаар аймаг, нийслэлийн Засаг даргад санал оруулж шийдвэрлүүлнэ.

4.14. Салбар зөвлөл нь ажлын албатай байх ба ажлын албаны чиг үүргийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар гүйцэтгэнэ.

## Тав. Эрүүл мэндийн байгууллага дахь ХСХ-ын алба/багийн чиг үүрэг

### 5.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах

5.1.1. ХСХ-ын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулж, хяналт тавьж ажиллана.

5.1.2. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ЭТҮХХ, ХСХ-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллана.

5.1.3. ХСХ-д шаардагдах санхүүжилтийг орон нутгийн болон улсын төсөвт тусган шийдвэрлэнэ.

5.1.4. Эрүүл мэндийн байгууллагын түвшинд ЭТҮХХ-ын эрсдэлийг бууруулах, сэргийлэх, хянахад нэгдмэл байдлаар буюу бүх хүний оролцоог ханган ажиллана.

5.1.5. Эрүүл мэндийн байгууллагууд нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан байгууллагын төрөл, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, түүний эрсдлээс хамаарч, тархвар/халдвар судлаач, халдварын сэргийлэлт, хяналтын эмч, халдварын сэргийлэлт, хяналтын сувилагчтай байна. /Хүснэгт1/

| №  | Эрүүл мэндийн байгууллага   | Тархвар/халдвар судлаач | ХСХ-ын эмч                    | ХСХ-ын сувилагч |
|----|---|-------------------------|-------------------------------|-----------------|
| 1  | Төрөлжсөн эмнэлэг   | ✓                       | ✓                             | ✓               |
| 2  | Нэгдсэн эмнэлэг   | ✓                       | ✓                             | ✓               |
| 3  | Тусгай эмнэлэг  | ✓                       | ✓                             | ✓               |
| 4  | Тусгай мэргэжлийн төв   | ✓                       | ✓                             | ✓               |
| 5  | Амаржих газар   | ✓                       | ✓                             | ✓               |
| 6  | Клиник  | Гэрээний дагуу          | Удирдлагын шийдвэрээр томилно | ✓               |
|    | мэс засал, эмэгтэйчүүд, арьс, уламжлалт анагаах ухаан, дуран, гэмтлийн тусламж үзүүлдэг бол | ✓                       | Удирдлагын шийдвэрээр томилно | ✓               |
| 7  | Хөнгөвчлөх, сувилгааны төвүүд   | Асаргаа, Гэрээгээр      | Удирдлагын шийдвэрээр томилно | ✓               |
| 8  | Сувилал 51-ээс дээш ортой   | ✓                       | Удирдлагын шийдвэрээр томилно | ✓               |
|    | Сувилал 50- хүртэл ортой  | Гэрээгээр               | -                             | ✓               |
| 9  | Сэргээн засах төв   | Гэрээгээр               | -                             | ✓               |
| 10 | Сувилахуйн төв  | Гэрээгээр               | -                             | ✓               |

|    |                                |   |                               |   |
|----|--------------------------------|---|-------------------------------|---|
| 11 | Сум дундын эмнэлэг             | - | Удирдлагын шийдвэрээр томилно | ✓ |
| 12 | Сум, тосгоны эрүүл мэндийн төв | - | Удирдлагын шийдвэрээр томилно | ✓ |
| 13 | Өрхийн эрүүл мэндийн төв       | - | Удирдлагын шийдвэрээр томилно | ✓ |

5.1.6. Тасаг нэгж бүрд ХСХ-ын асуудал хариуцсан ажилтанг томилж, давхар ажил гүйцэтгэж байгаа бол ажлын цагийн зохицуулалт хийсэн байна.

5.1.7. ЭТҮХХ-аас сэргийлэх асуудлаар эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана.

5.1.8. ЭТҮХХ-ын тандалт судалгаа хийж, халдварыг эрт илрүүлэн мэдээлж, хариу арга хэмжээ авна.

5.1.9. ЭТҮХХ-ын тохиолдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулна. Онош баталгаажуулах, давтан шинжилгээ хийх зорилгоор эмнэлзүйн сорьц, нянгийн омгийг зохих нөхцөлд хадгалсан байна.

5.1.10. ЭТҮХХ-ын дэгдэлт гарсан болон халдвар гарах эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээ авахад тухайн эрүүл мэндийн байгууллагын чадамж хүрэхгүй тохиолдолд мэргэжлийн туслалцаа авч ажиллана.

5.1.11. Бичил биетний тэсвэржилттэй уялдуулан түүний эсрэг эм, бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж ажиллана.

5.1.12. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд шаардлагатай мэдээлэл өгнө.

5.1.13. Тандалт, судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж харъяалах болон бусад тасаг нэгж, эрүүл мэндийн ажилтнуудад эргэн мэдээлнэ.

5.1.14. Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд болон лабораторийн шинжилгээний үр дүн (олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдвар болон олон эмэнд тэсвэртэй бичил биетний халдвартай зэрэг)-г цаг алдалгүй мэдээлнэ.

5.1.15. Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгална.

5.1.16. Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

5.1.17. Эрүүл мэндийн байгууллагад дадлага хийж байгаа оюутан, дадлагажигч эмч ХСХ-ын дэглэмийг дагаж мөрдөх ба халдвараас сэргийлэх зорилгоор эмнэлзүйн дадлагад гарахаас өмнө урьдчилан сэргийлэх шинжилгээ, дархлаажуулалтад хамрагдсан байна.

5.1.18. Эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариун цэврийн бүтээгдэхүүн, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн тооцоог гаргаж, хангана.

5.1.19. Эрүүл мэндийн байгууллага нь олон улсад худалдаалах зөвшөөрөлтэй, улсын бүртгэлд бүртгэгдсэн, эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх зориулалт бүхий чанарын шаардлага хангасан ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.



5.1.20. Эмнэлгийн байр орчинд хортон шавж, мэрэгч үүрлэх, тархахаас урьдчилан сэргийлж ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийг жилд хоёр удаа, шавж мэрэгч үүрлэсэн тохиолдол бүрд мэргэжлийн байгууллагаар устгал хийлгэнэ.

5.1.21. Халдвараас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэж, арилгуулах арга хэмжээг авна.

5.1.22. Өөрсдийн санаачлагаар ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулахад оролцож ажиллах сонирхолтой сайн дурын ажилтан, мэргэжилтний санал, санаачлагыг дэмжиж, байгууллагын дотоод журмаар зохицуулан ажиллана.

5.1.23. ХСХ-ын чиглэлээр амжилт гаргасан, дэмжлэг үзүүлсэн байгууллага, тасаг, нэгж, эмнэлгийн ажилтнуудын үйл ажиллагаа, туршлагыг сурталчилж, урамшуулна.

## **5.2. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх:**

5.2.1. Эрүүл мэндийн ажилтны урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд эмчлэх, эрүүлжүүлэх асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.

5.2.2. Эрүүл мэндийн байгууллага нь “Ажлын байрны аюулгүй байдал, ажилтны эрүүл мэнд” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

5.2.3. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдах халдвараас эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалах, уг халдвар илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мэдлэг дадал олгосон байна.

5.2.4. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх зорилгоор дархлаажуулах ажлыг зохион байгуулж, дархлаажуулалтын талаар нэгдсэн бүртгэл судалгаатай байна.

5.2.5. Цусаар дамжих халдвартай эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийн байдалд жилд 2 удаа хяналт тавьж, вирусийн идэвхжилийг хянаж, халдвараас сэргийлэх арга хэмжээний заавар зөвлөгөө өгнө.

5.2.6. Эрүүл мэндийн байгууллагад дадлага хийж байгаа оюутан, дадлагажигч эмч дадлага хийх хугацаанд халдварт өртөхөөс сэргийлж байгууллагын дотоод журам зааврыг танилцуулж, мөрдүүлнэ.

5.2.7. Ажил олгогч нь эрүүл мэндийн ажилтныг ажлын байранд гарахын өмнө халдварын сэргийлэлт, хяналтын сургалтад хамруулж, мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийн талаар санамж, зөвлөгөө өгч, хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.

5.2.8. Тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, халдварт өртсөн байж болох тохиолдолд эрсдлийг үнэлэн, шаталсан арга хэмжээ хэрхэн авах талаарх мэдээллээр ажилтнуудыг бүрэн хангана.

5.2.9. Эрүүл мэндийн ажилтан цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдлыг бүртгэж сэргийлэлтийн арга хэмжээг авч ажиллана.

5.2.10. Ажилтнуудын эрүүл мэндийн талаарх мэдээллийн нууцыг хадгална.



### **5.3. Үйлчлүүлэгчдийг халдварт өртөх эрсдлээс сэргийлэх:**

5.3.1. Эрүүл мэндийн байгууллага нь тухайн эмнэлгээр үйлчлүүлж, буй иргэд халдварт өртөх эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч ажиллана.

5.3.2. Эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд шаардлагатай мэдээлэл өгнө.

5.3.3. Эрүүл мэндийн байгууллага нь халдвараас сэргийлэх дэглэмийг чанд баримтлан цэвэр орчинд, ариун багаж хэрэгслээр үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

5.3.4. Үйлчлүүлэгч халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдолд үйлчлүүлэгч болон түүний асран хамгаалагчид мэдэгдэж, халдвараас сэргийлэх арга хэмжээ, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний зөвлөгөө авна.

### **Зургаа. Халдварын сэргийлэлт, хяналтын сургалт**

6.1. Эрүүл мэндийн байгууллага нь шинэ ажилтанд ХСХ-ын чиглэлээр эмнэлэгт мөрдөх журам, зааврыг таниулах баримжаа олгох сургалтыг ажилд орохоос өмнө хийнэ.

6.2. Эрүүл мэндийн байгууллага нь ажилтны мэдлэг, дадал, хандлагын үнэлгээ хийж, сургалтын хэрэгцээг тодорхойлсон байна.

6.3. Эрүүл мэндийн ажилтны ХСХ-ын мэдлэг, дадлыг сайжруулах сургалт, сурталчилгаа, аян, мэдээлэл өгөх ажлыг жил бүр тасралтгүй зохион байгуулна.

6.4. ХСХ-ын суурь мэдлэг олгох үндсэн сургалтын агуулгад гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадал олгох, хог хаягдлын ангилан ялгалт, багаж, материалын зөв хэрэглээ, хурц үзүүр иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах, халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртөхөөс сэргийлэх, өртсөн үед халдвараас сэргийлэх, хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зөв хэрэглэх зэрэг сэдвүүд багтсан байна.

6.5. Суурь мэдлэг олгох сургалтад эрүүл мэндийн байгууллагын бүх ажилтныг хамруулна.

6.6. Үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд оролцон ажилладаг, цус, биологийн шингэнтэй харьцдаг зорилтод бүлгийн ажилтныг үндсэн сургалтаас гадна нэмэлтээр ажлын байрны онцлогт тохируулан сургалтад жил бүр хамруулна.

6.6. ХСХ-ын сургалтыг ХСХ-ын сургагч багшаар бэлтгэгдсэн, дадлага, туршлагатай мэргэжилтэн хийнэ.

6.7. ХСХ-ын сургалтыг онол, дадлага хослуулан, зайн болон бие даан суралцах, оролцогчдын оролцооны аргад тулгуурласан олон хэлбэрээр хийх ба сургалтын орчин, хэрэгслийг бүрдүүлсэн байна.

6.8. Сургалтад оролцогчдын ХСХ-ын мэдлэг, дадал, хандлагыг үнэлж, чадамжийн гэрчилгээ олгох, сургалтын бүртгэл хөтөлсөн байна.

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29-ны  
өдрийн 1586 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

### 1. ТАРХВАР СУДЛААЧ/ХАЛДВАР СУДЛААЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ

|  |   |
|--|---|
| <b>АЛБАН<br/>ТУШААЛЫН НЭР</b>          | Тархвар судлаач/ Халдвар судлаач  |
| <b>АЛБАН<br/>ТУШААЛЫН<br/>ЗОРИЛГО:</b> | Тухайн эрүүл мэндийн байгууллагад ЭТҮХХ гарах эрсдлээс урьдчилан сэргийлэх, халдвараас сэргийлэх арга хэмжээнд хяналт тавих, ЭТҮХХ, халдварт өвчин гарсан тохиолдолд хариу арга хэмжээг авах, тандалт судалгаа хийх, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох  |
| <b>АЛБАН<br/>ТУШААЛЫН<br/>ЗОРИЛТ</b>   | <ol style="list-style-type: none"> <li>1. ЭТҮХХ-ын тандалт, судалгаа</li> <li>2. ЭТҮХХ-ас сэргийлэх арга хэмжээ</li> <li>3. Эрсдлийн үнэлгээ/Өвчтөний аюулгүй байдал</li> <li>4. Бичил амь судлалын лабораторитай хамтын ажиллагаа</li> <li>5. Эм зүйн тасагтай нягт хамтын ажиллагаа</li> <li>6. Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг шуурхай авах</li> <li>7. Эмнэлгийн хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдалд тавих хяналт</li> <li>8. Эрүүл мэндийн мэргэжилтэнд ХСХ-ын зайлшгүй шаардлагатай чиг баримжаа олгох</li> <li>9. Ариутгалын тоног төхөөрөмж, халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн хэрэгслийн сонголтод оролцох</li> </ol>                         |
| <b>ХӨДӨЛМӨРИЙН<br/>НӨХЦӨЛ</b>          | Хэвийн бус, халдвартай нөхцөл   |
| <b>ТАВИГДАХ<br/>ШААРДЛАГА</b>          | <ol style="list-style-type: none"> <li>1) Нийгмийн эрүүл мэнд, Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн</li> <li>2) Эрүүл ахуйч, тархвар судлаач эмч, нийгмийн эрүүл мэнд судлаач</li> <li>3) Тархвар судлаачийн олгох курс, ХСХ-ын чиглэлээр сургалтад хамрагдсан байх</li> </ol>  |
| <b>ЧИГ ҮҮРЭГ</b>                       | <u>ЭТҮХХ-ын тандалт, судалгаа</u> <ul style="list-style-type: none"> <li>- Идэвхигүй болон идэвхитэй тандалт хийх удирдамж, тушаалын заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах</li> <li>- ЭТҮХХ, халдварт болон халдварт бус өвчлөлийн байдалд тандалт, судалгаа хийж шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох</li> <li>- Дэгдэлтийн судалгаа хийх, дүгнэлт гаргах, таслан зогсоох арга хэмжээ авах</li> <li>- ЭТҮХХ-ын тохиолдол бүрт судалгаа хийх</li> <li>- ЭТҮХХ-ын дэгдэлт гарсан болон халдвар гарах эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээ авахад тухайн эрүүл мэндийн байгууллагын чадамж хүрэхгүй тохиолдолд мэргэжлийн туслалцаа авч ажиллах</li> </ul> |

#### ЭТҮХХ-аас сэргийлэх үйл ажиллагаа

- Халдварын хяналт, сэргийлэлтийн үндсэн шаардлагуудын мөрдөлтөнд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр удирдах
- Байгууллагын хэмжээнд халдварын сэргийлэлт, хяналт, эрүүл ахуйн чиглэлээр сургалтыг тасралтгүй зохион байгуулах, зөвлөмж, гарын авлага материалаар хангах
- Халдвар хяналтын ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
- ХСХ стратегийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
- Халдварын сэргийлэлт, хяналтын өртөг багатай, үр дүн сайтай аргыг эрэлхийлэх нэвтрүүлэх
- ХСХ-д шаардлагатай төсөв, хэрэгслийн тооцоог гаргах, нөөцийг тогтоох

#### Эрсдэлийн үнэлгээ/Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал

- ЭТҮХХ, халдварт өвчний дэгдэлт гарч болох эрсдэлт хүчин зүйлийг тогтоох
- Эмнэлгийн тулгамдсан асуудал болон эрсдэл өндөр тасаг, нэгжийг тогтоох, халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- Эрсдэлийг үнэлэх, нотолгоонд тулгуурлан бууруулах арга хэмжээ авах
- Эрсдэлтэй уялдуулан ХСХ-ын бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтэнд хяналт тавих

#### Бичил амь судлалын лабораторитай хамтын ажиллагаа

- Лабораториос мэдээ, мэдээллийг шуурхай авах, хариу арга хэмжээг авч ажиллах
- Лабораторийн шинжилгээний үр дүнд дүн шинжилгээ хийх
- Олон эмэнд тэсвэртэй бичил биетэн, сэрэмжлүүлэх бичил биетэн, сэрэмжлүүлэх нөхцөл байдал гарсан тохиолдолд эмнэлэгт халдвар тархаахгүй байх арга хэмжээг авах
- Тохиолдлын болон өвчлөлийн түвшин тогтоох илрүүлэг шинжилгээний хариунд дүгнэлт хийх
- Бичил биетний эсрэг эмийн хэрэглээнд хамтран дүн шинжилгээ хийх
- Лабораторийн био-аюулгүй ажиллагаанд хяналт тавих

#### Эм зүйн тасагтай хамтын ажиллагаа

- Антибиотик мэдрэг чанарын шинжилгээний дүнг эмчилгээнд ашиглаж байгаа байдлыг хянах
- Антибиотикийн хэрэглээ, сонголтонд эмийн эмчилгээний хороотой хамтран хяналт тавих
- Антибиотикт тэсвэртэй бактери үүсэхээс сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх

Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг шүүрхай авах

- Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварын үед авах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах
- Дэгдэлт, ЭТҮХХ, буюу халдварын үед авах арга хэмжээг төлөвлөх.

Эмнэлгийн хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдалд тавих хяналт

- Эмнэлгийн хоолны үйлчилгээ, хоол тэжээл бэлтгэн нийлүүлэгчдийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамрагдсан байдалд хяналт тавих, хамрагдах шаардлага тавих
- Эмнэлгийн хоолны үйлчилгээ эрхлэгчдэд эрүүл ахуйн зохистой дадал мөрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах
- Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах журам, техникийн зохицуулалтанд хяналт тавих

Эрүүл мэндийн мэргэжилтэнд ХСХ-ын зайлшгүй шаардлагатай чиг баримжаа олгох

- Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд мэргэжлийн зайлшгүй шаардлагатай чиг баримжааг олгох
- Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны “Мэргэжлийн чиглүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан, сургалтыг зохион байгуулах,
- Шинэ ажилтанг чиглүүлж, дадлагажуулсан “Чиглүүлэх сургалт”-ын үр дүн, дүгнэлтийг эмнэлгийн удирдлагын зөвлөлд танилцуулах,

Ариутгалын тоног төхөөрөмж, халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн хэрэгслийн сонголтод оролцох

- Тоног төхөөрөмж ялангуяа ариутгах, халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийн сонголтод оролцох, хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн сонголтод оролцох
- Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх бодисын сонголтод оролцох

## 2. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЭМЧИЙН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Эмнэлэг, тасаг, нэгж дэх халдварын сэргийлэлт, хяналтын эмч нь халдварын сэргийлэлт, хяналт болон эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх чиглэлээр сургалтанд хамрагдсан байна. Халдварын сэргийлэлт, хяналт хариуцсан эмч, үндсэн үүрэгт ажил дээр байгууллагын шийдвэрээр хавсран ажиллаж байгаа үед нэмэлт хөлс олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллага шийдвэрлэнэ.

**ХСХ-ын эмчийн ажлын зорилго:** Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх.

### **Ажлын үндсэн зорилт:**

1. Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх
2. ХСХ-ын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих
3. Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авах

### **Үйл ажиллагааны үндсэн чиглэл:**

#### I үндсэн зорилтын хүрээнд:

1. Эмнэлэгт мөрдөх бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээний журмыг боловсруулж, хэлэлцүүлэн батлуулна
2. Бичил биетний эсрэг эмийн хэрэглээний байдалд хяналт тавьж, тасаг нэгжээр хуваарь гарган сар тутам үнэлгээ хийнэ.
3. Эмнэл зүйч эмч нарт бичил биетний эсрэг эмийн хэрэглээний талаар зөвлөмж, заавар өгнө.
4. Эмнэлзүйн бичил амь судлалын лабораторийг удирдлагаар ханган, өдөр тутмын үйл ажиллагааны зөвлөгөө өгнө

#### II үндсэн зорилтын хүрээнд:

1. ХСХ-ын чиглэлээр тархвар/халдвар судлаач, халдвар хяналтын сувилагчтай хамтран ажиллана.
2. Эмнэлгийн ХСХ-ын албаны журамд заасан ажлын хэрэгжилтийг хянаж, чиглүүлэн ажиллана.
3. ХСХ-ын сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.
4. ХСХ-ын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах ажлаар эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

#### III үндсэн зорилтын хүрээнд:

1. Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэнд, дархлаажуулалтын асуудалд хяналт тавьж ажиллана.
2. Халдварт авах эрсдэлт өртсөн үед өртөлтийн дараах халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.
3. Өртөлтөөс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллана.



### **3.ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН СУВИЛАГЧИЙН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ**

Эрүүл мэндийн байгууллага, тасаг, нэгж дэх ХСХ-ын сувилагч нь орон тооны болон орон тооны бус байх бөгөөд ХСХ болон ЭТҮХХ-аас сэргийлэх чиглэлээр сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн байна. Тухайн асуудлыг хариуцсан ажилтанд нэмэлт хөлс олгох асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн байгууллага шийднэ.

**ХСХ-ын сувилагчийн ажлын зорилго:** ЭТҮХХ-аас сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх.

#### **Ажлын үндсэн зорилт:**

- 1) ХСХ-ын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих
- 2) ЭТҮХХ-ын тандалт хийх, эрт илрүүлэн мэдээлэх, хариу арга хэмжээ авах
- 3) Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авах

#### **Үйл ажиллагааны үндсэн чиглэл:**

##### I үндсэн зорилтын хүрээнд:

1. Байгууллагын ЭТҮХХ, ХСХ-ын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
2. ЭТҮХХ-ын эрсдэлийг бууруулах, сэргийлэх, хянах, тасгийн эмч, эмнэлгийн ажилтны оролцоог дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулна.
3. Эрсдэл өндөртэй ажилбаруудыг хянах хуудсаар шалгадаг байна.
4. ХСХ-ын чиглэлээр хийгдэж буй ажлын тайланг цаг тухайд нь гаргах, тасгийн эмч, ажилтнуудад танилцуулах, эмнэлгийн тархвар/халдвар судлаачид хүргэнэ.
5. Тасгийн эмч, ажилтнуудын:
  - 5.1. Гар угаах, халдваргүйжүүлэх
  - 5.2. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг зөв, зохистой хэрэглэх
  - 5.3. Хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах
  - 5.4. Цусаар дамжих халдвараас сэргийлэх
  - 5.5. Багаж хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх
  - 5.6. Ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг найруулах, хэрэглэх асуудалд хяналт тавьж, хэрэгжүүлнэ.

##### II үндсэн зорилтын хүрээнд:

1. ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг хийх, мэдээлэх
2. Үйлчлүүлэгч болон тасгийн эмч, мэргэжилтэнд ЭТҮХХ-аас сэргийлэх мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах
3. ЭТҮХХ-аас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэх, арилгуулах арга хэмжээг авах

##### III үндсэн зорилтын хүрээнд:

1. Эрүүл мэндийн ажилтныг дархлаажуулалтад хамруулах, эрүүл мэндийн байдалд хяналт тавих, үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд оролцоно.
2. Эрүүл мэндийн ажилтан цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, өртөлтийн дараах арга хэмжээг авч ажиллана.



Эрүүл мэндийн сайдын  
 2019 оны 11 сарын 29 ны  
 өдрийн А/БЗБ дугаар тушаалын  
 гуравдугаар хавсралт

**ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙГДЭХ  
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ**

| №  | Чиглэл  | Өрхийн ЭМТ | Сум, тосгоны ЭМТ | Сум дундын эмнэлэг | Амаржих газар | Нэгдсэн эмнэлэг/ БОЭТ | Сувилал | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг | тусгай эмнэлэг | Тусгай мэргэжлийн төв | Клиник   |       | Хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвүүд | Сэргээн засах төв | Сувилахуйн төв |
|----|---|------------|------------------|--------------------|---------------|-----------------------|---------|------------------------------|----------------|-----------------------|--|-------|---------------------------------------|-------------------|----------------|
|    |   |            |                  |                    |               |                       |         |                              |                |                       | М эс, засал, шүд, эмэгтэйчүүд, Хүүхэд уламжлалт, дуран, арьс гэмтлийн тусламж үзүүлдэг | Бусад |                                       |                   |                |
| 1  | ХСХ-ын орон тооны албатай байх                                      | √          | √                | √                  | √             | √                     | √       | √                            | √              | √                     | √  | √     | √                                     | √                 | √              |
| 2  | Орон тооны бус ХСХ-ын багтай байх                                   |            |                  |                    | √             | √                     |         | √                            | √              | √                     |  |       |                                       |                   |                |
| 3  | ХСХ-ын асуудал хариуцсан тархвар/халдвар судлаачтай байх            | √          | √                | √                  | √             | √                     | √       | √                            | √              | √                     | √  | √     | √                                     | √                 | √              |
| 4  | ХСХ-ын асуудал хариуцсан эмнэл зүйч эмчтэй байх                     |            |                  |                    | √             | √                     | √       | √                            | √              | √                     | √  |       |                                       |                   |                |
| 5  | ХСХ-ын асуудал хариуцсан халдвар хяналтын сувилагчтай байх          | √          | √                | √                  | √             | √                     |         | √                            | √              | √                     | √  |       |                                       |                   |                |
| 6  | ЭТҮХХ-ын эрсдлийг тогтоосон байх                                    | √          | √                | √                  | √             | √                     | √       | √                            | √              | √                     | √  | √     | √                                     | √                 | √              |
| 7  | Бичил биетний эсрэг эмэнд мэдрэг байдлыг тодорхойлох шинжилгээ хийх |            |                  |                    | √             | √                     |         | √                            | √              | √                     |  |       |                                       |                   |                |
| 8  | Бичил биетний эсрэг эмийн хэрэглээний байдлыг судалж, хянадаг байх  | √          | √                | √                  | √             | √                     | √       | √                            | √              | √                     | √  | √     |                                       |                   |                |
| 9  | Бичил амь судлалын лаборатори нь чанарын гадаад хяналтад хамрагдах  |            |                  |                    | √             | √                     |         | √                            | √              | √                     |  |       |                                       |                   |                |
| 10 | Халдварын сэргийлэлт, хяналтын сургалт зохион байгуулдаг байх       | √          | √                | √                  | √             | √                     | √       | √                            | √              | √                     | √  | √     | √                                     | √                 | √              |
| 11 | Эмэнд тэсвэртэй бичил биетний тандалт хийдэг байх                   |            |                  |                    | √             | √                     |         | √                            | √              | √                     |  |       |                                       |                   |                |
| 12 | Мэс заслын дараахь шархны халдвар илрүүлэх тандалт хийх             | √          | √                | √                  | √             | √                     | √       | √                            | √              | √                     | √  | √     | √                                     | √                 | √              |
| 13 | Шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвар илрүүлэх тандалтын      |            |                  | √                  | √             | √                     |         | √                            | √              | √                     | √  |       |                                       |                   |                |

|    |  |   |   |   |   |   |   |   |   |   |   |   |   |   |   |
|----|--|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгаа илрүүлэх  |   |   | √ | √ | √ |   | √ | √ | √ | √ |   |   |   |   |
| 15 | Судасны гуурстай холбоотой халдвар илрүүлэх тандалт хийх   |   |   | √ | √ | √ |   | √ | √ | √ | √ |   |   |   |   |
| 16 | ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг хийж мэдээлдэг байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |   |   |
| 17 | Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийдэг байх   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 18 | Ариутгалын тасаг, хэсэгтэй байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 19 | Ариутгалын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлдэг  |   |   |   |   | √ |   |   |   | √ | √ | √ | √ | √ |   |
| 20 | Ариутгалын чанарт дотоод хяналт тавьдаг, хими, физик, уурын нэвчилт, биологийн хяналт тавьдаг байх   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 21 | Нэг удаагийн хэрэгслийг давтан хэрэглэдэггүй байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 22 | Үйлчлүүлэгчдэд ЭТҮХХ-аас сэргийлэх мэдээлэл өгдөг байх   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 23 | ЭМА-ыг халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагаанд оролцуулдаг байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 24 | Тусгаарлах өрөөтэй, сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарладаг байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 25 | ЭМА-ын эрүүл мэндийн байдалд хяналт тавьж үзлэг, шинжилгээнд хамруулах   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 26 | ЭМА-ыг халдварт өртөхөөс сэргийлэх арга хэмжээ авдаг байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 27 | ЭМА-ыг В гепатитын 3 тун вакцинаар дархлаажуулах   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 28 | В гепатитын дархлаа тогтоцын шинжилгээнд хамруулсан байх   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 29 | ЭМА бүрийг гар угаах, халдваргүйжүүлэх заавраар хангасан байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 30 | ЭМА гарын эрүүл ахуй сахилтын үнэлгээг хийж түвшинг тогтоосон байх   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 31 | ЭМА-ыг эмнэлэгт хэрэглэж байгаа ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг найруулах, хэрэглэх заавраар хангасан байх                            | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 32 | ЭМА бүрийг хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавраар хангах  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 33 | ЭМА бүрийг хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах заавраар хангах   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 34 | ЭМА бүрийг цусаар дамжих халдвараас сэргийлэх заавраар хангасан байх   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 35 | Багаж хэрэгслийг зааврын дагуу цэвэрлэж, халдваргүйжүүлж, ариутгадаг байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 36 | Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэдэг байх                      | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 37 | Халдварын эрсдэл өндөртэй ажилбаруудыг хянах хуудсаар шалгадаг байх  | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 38 | Эмнэлгийн мэргэжилтэн ХСХ-ын багц цагийн сургалтад хамрагдах   | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 39 | Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээнд хяналт тавих багтай байх   | √ | √ | √ | √ | √ |   | √ | √ | √ |   |   |   |   |   |
| 40 | Гепатитын В вирусийн халдварт өртөх эрсдэлтэй өндөртэй үйлчлүүлэгчийг (гемодиализ, дархлаа дарангуйлах эмчилгээ гэх мэт) дархлаажуулдаг байх | √ | √ | √ | √ | √ |   | √ | √ | √ |   |   |   |   |   |